

**НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ
АЛБАНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.02.15

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /НТОЗШША/-ны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

НТОЗШША-ны 2024 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 2 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **85,7%-тай** үнэлэгдлээ. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, хууль тогтоомж, тушаал шийдвэрээр өгсөн үүрэг даалгавар байхгүй, shilen.gov.mn сайтад НТОЗШША бүртгэгдээгүй тул үнэлгээнд оруулаагүй болно.

2.1. НТОЗШША-ны 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
17	11	1	3	2	-	-	-	88.2%

2.2. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	хамаа ралгүй	
Нийт	46	8	1	1	1	35	81,8%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

НТОЗШША нь ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг ЗТХЯ-ны Гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, хүрэх түвшинг улирал бүрээр төлөвлөн Зам, тээврийн хөгжлийн яамны холбогдох газруудаар хянуулж, батлан ажилласан байна.

2. Хэрэгжилтийн байдал:

- 1) НТОЗШША-ны 2024 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 2 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **85,7%-тай** үнэлэгдлээ. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, хууль тогтоомж, тушаал шийдвэрээр өгсөн үүрэг даалгавар байхгүй, shilen.gov.mn сайтад НТОЗШША бүртгэгдээгүй тул үнэлгээнд оруулаагүй болно.
- 2) Шинжлэн шалгасан осол, зөрчлийн тайлан удаашралтай, тайлангийн тоо өмнөх онуудаас буурч байгаад анхаарч ажлын зохион байгуулалтыг сайжруулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн 2024 онд нийт 6 осол, ноцтой зөрчил дээр шинжлэн шалгах ажиллагаа явуулж, 2 эцсийн тайлан, 4 урьдчилсан тайлан гаргаж ажилласан байна.
- 3) НТОЗШША-наас гаргасан зөвлөмжүүдээс хэрэгжээгүй үлдсэн 17 зөвлөмжийн хэрэгжилт энэ оны эхний хагас жилийн байдлаар 100% хэрэгжсэн-9, 50%-ийн хэрэгжилттэй 3, 30%-ийн хэрэгжилттэй 4, хаасан 1 зөвлөмж, нийт 73,1%-тай байна.
- 4) Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг хадгалах, дэмжих, урамшуулах чиглэлээр тодорхой ажил төлөвлөн 3 ажилтныг сургалтад хамруулан ажиллагсдын цалин хөлсийг 10 хувиар нэмэгдүүлсэн байна.
- 5) Шинжлэн шалгах ажиллагаанд дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх судалгаа хийсэн боловч төсөв санхүүгийн асуудал шийдэгдээгүй тул хэрэгжээгүй байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Албаны бүтэц, орон тоо, дүрмийг яаралтай шинэчлэн 2025 оны I сард багтаан батлуулах;
2. Шинжлэн шалгах ажиллагаанд дэвшилтэт техник технологи, инновацыг нэвтрүүлэх, хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийн худалдан авах зардлыг 2025 оны төсөвт тусган хэрэгжүүлэх;
3. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэн тайланг улирал бүр Зам, тээврийн яаманд ирүүлэх;
4. Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах, болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хавсралтаар Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг 5 хэсгийн 98 нээлттэй мэдээллээс өөрт хамаарах асуудлыг shilen.gov.mn сайтад тайлагнаж ажиллахаар шийдвэрлэсний дагуу тус сайтад бүртгүүлэн холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь байршуулах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР